



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/123

Булган сум

“Соотон чоно” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1-д дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Баяннуур сумын төрийн албан хаагчийн орон сууцны барилгын засварын ажлын нэмэлт цахилгаан хангамжийн ажлыг 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгөөр “Соотон чоно” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Соотон чоно” ХХК-ийн захирал (Г.Ганбаяр)-д үүрэг болгосугай.

3.Булган аймаг Баяннуур сумын төрийн албан хаагчийн орон сууцны барилгын засварын нэмэлт цахилгаан хангамжийн ажилд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Баяннуур сумын төрийн албан хаагчийн орон сууцны барилгын засварын нэмэлт цахилгаан хангамжийн ажлыг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын ажлын батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5.Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэж хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Баяннуур сумын Засаг дарга (Б.Ёндон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010186